



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/327

Мөрөн сум

Дипломат, гадаад албан паспорт олгох
хүсэлт уламжлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын 2.2.2, 3.7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Засаг дарга Д.Отгонбаяр, тус сумын Засаг даргын Тамгын газрын дарга О.Энхтүвшин нар 2022 оны 10 дугаар сарын 3-наас 2022 оны 10 дугаар сарын 10-ны хооронд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зорчиж жижиг дунд үйлдвэрүүдтэй танилцах, ажлын байрны туршлага солилцохоор төлөвлөж байгаа тул албан паспорт олгуулах хүсэлтийг Гадаад харилцааны яаманд уламжилсугай.

2. Гадаад улсад албан томилолтоор ажилласан тухай бүртээ холбогдох мэдээллийг илтгэх хуудсаар аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Рэнчинлхүмбэ сумын Засаг дарга (Д.Отгонбаяр), Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын дарга (О.Энхтүвшин) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН